



БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭЛТИЙН ТАЙЛАН

Байгууллагын нэр: **НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДОТООД АУДИТ, МОНИТОРИНГИЙН ГАЗАР**

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН

2026

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДОТООД АУДИТ, МОНИТОРИНГИЙН ГАЗАР

Тайлангийн хамрах хугацаа: 2026.01.01-2026.06.30

Тайлан илгээгч:

Дотоод аудит, мониторингийн
газрын дарга

Б.Ганхуяг

Боловсруулсан:

Дотоод аудит, мониторингийн
газрын ахлах мэргэжилтэн

Н.Болормаа

Хүлээн авагч:

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын
яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ,
дотоод аудитын газрын мэргэжилтэн

.....

1. Ерөнхий мэдээлэл

Дотоод аудит, мониторингийн газар нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/25 дугаар тушаал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны А/22 дугаар тушаал, 2024 оны А/53 дугаар тушаал, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/163 дугаар тушаал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/237 дугаар тушаалын дагуу 2018 оны 04 сарын 01-ний өдрөөс эхлэн дарга /1/, ахлах мэргэжилтэн /1/, мэргэжилтэн /4/ нийт 6 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус газар нь Нийгмийн даатгалын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, нийгмийн даатгалын салбарын хууль тогтоомжийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, үйл ажиллагааны зардлын зарцуулалтад аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, Шилэн дансны тухай хууль болон Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, удирдлагыг бодит мэдээллээр хангах чиг үүргийн дагуу ажлаа төлөвлөж биелэлтэд нь хяналт тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд **123** хүн/өдөр ажилласан ба дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

2. Салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт, илэрсэн асуудлууд

2.1. Нийгмийн даатгалын төв сангийн орлого, зарлагын гүйлгээ, төвлөрсөн орлогыг нийгмийн даатгалын холбогдох санд хэрхэн хуваарилж байгаа байдалд аудит хийх;

“Нийгмийн даатгалын төв сангийн орлого, зарлагын гүйлгээ, төвлөрсөн орлогыг нийгмийн даатгалын холбогдох санд хуваарилж байгаа байдалд 2026 оны 1 дүгээр улирлын байдлаар аудитыг хийж байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны А/183 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, санхүүжилт олгох, хяналт тавих журам”-ын хэрэгжилтэд Нийгмийн даатгалын төв орлого, зарлагын гүйлгээг дансны харилцахын хуулга, анхан шатны баримтын бүрдэлд үндэслэн дараах асуудлын хүрээнд хийж гүйцэтгэж байна. Үүнд:

- Төв сангийн орлого бүрдүүлэлт, зарцуулалт;
- Холбогдох санд хуваарилж байгаа байдал;

Аудитын дүн мэдээг нэгтгэн дүгнэлт, зөвлөмж гарган цаашид арга хэмжээний саналыг боловсруулан удирдлагад танилцуулахаар бэлтгэж байна.

2.2. Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийх;

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны А/05, А/62, А/89, А/118, А/133, 150 дугаар тушаалаар баталсан удирдамжийн дагуу Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын газарт 2023 оны 07-12 дугаар сар, 2024, 2025 он, Налайх дүүргийн Нийгмийн даатгалын газарт 2023-2025 он, Орхон аймгийн Нийгмийн даатгалын газарт 2019-2023 он, Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын газарт 2024-2025 оныг хамруулан шалгалтаар байгууллагын

санхүү, үйл ажиллагааны зардлын зарцуулалтад төлөвлөгөөт хяналт, шалгалт хийж илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулж, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж ажиллав

Байгууллагын санхүү үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар нийт 159.6 сая төгрөгийн зөрчил илэрснээс:

- 76.8 зөрчилд төлбөрийг нөхөн төлүүлэхээр 13 санхүүгийн улсын байцаагчийн акт;
- 13 зөрчилд зөрчлийг арилгах тухай 10 албан шаардлага;
- 9 зөрчилд 2 зөвлөмжийг тус тус хүргүүлж ажиллав.

Илэрсэн зөрчлийг аймаг, дүүрэг тус бүрээр харуулбал:

/сая.төг/

Газрын нэр	Тогтоосон							
	Төлбөрийн акт		Албан шаардлага			Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Зөрчлийн тоо	Дүн	Тоо	Зөрчлийн тоо	Дүн
Хан-Уул дүүрэг	2	8.6	1	2		1	2	
Налайх дүүрэг	9	48.2	8	10	67.6	1	7	12.3
Орхон аймаг	2	19.9	1	1	2.9			
	13	76.8	10	13	70.5	2	9	12.3

Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын газарт хийсэн хяналт шалгалтын дүн мэдээг Газрын даргын зөвлөлд 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдөр, Налайх дүүрэг, Орхон аймгийн Нийгмийн даатгалын газарт хийсэн хяналт шалгалтын дүн мэдээг 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн хуралд танилцуулав.

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын газарт хийсэн хяналт шалгалтын дүнг Газрын даргын зөвлөлд танилцуулахаар бэлтгэж байна.

2.3. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ;

2.3.1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;

Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийгмийн даатгалын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ хийв.

Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын 2024 оны 218 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-д нийгмийн даатгалын чиглэлээр хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг харуулбал:

Зорилт, арга хэмжээний дугаар	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь
-------------------------------	----------------------------------	-------------------

2.1. ЧИНЭЭЛЭГ МОНГОЛ ХҮН		
2.1.1.1. Нийгмийн даатгалын тогтолцоог сайжруулж, иргэн бүрд хуримтлалын сан бүрдүүлж, эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зориулалтаар ашиглах, тэтгэврээ өвлүүлэх, урьдчилан ашиглах боломжийг бүрдүүлнэ.		
2.1.1.1.	Хагас хуримтлалын тогтолцоонд шилжих шинэчлэлийг үргэлжлүүлж тэтгэврийн даатгалын шимтгэлийн 2 хувийг хуримтлуулах;	90
2.1.1.1.	Нийгмийн даатгалын хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;	90
2.1.1.22	Тэтгэврийн хэмжээг өмнөх оны инфляцын жилийн дундаж болон хүн амын амьжиргааны доод түвшинтэй уялдуулан жил бүр нэмэгдүүлнэ.	100
2.1.3.НИЙГМИЙН БАТАЛГАА		
2.1.3.2.Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөж, нийгмийн даатгалын үйлчилгээг даатгуулагчийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн, их өгөгдөлд тулгуурлан, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран цахимаар авах боломжийг бүрдүүлнэ		
2.1.3.2	Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх;	78.5
	Нийгмийн даатгалын үйлчилгээг их өгөгдөлд суурилан бүрэн цахимжуулж, тоног төхөөрөмжийг шинэчлэх;	90
2.1.3.3.Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагч бүрийг "Миний тэтгэврийн мөнгөн хуримтлал"-тай болгож, тэтгэврийн шинэчлэлийг үргэлжлүүлнэ.		
2.1.3.3.	Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагч бүрийг "Миний тэтгэврийн мөнгөн хуримтлал"-тай болгож, тэтгэврийн нөөц санг бүрдүүлэх;	93.9
2.1.3.4.Хагас хуримтлалын тогтолцоонд шилжиж, тэтгэврээ өвлүүлэх, урьдчилан ашиглах хууль, эрх зүйн зохицуулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.		
2.1.3.4.	Тэтгэврээ өвлүүлэх, урьдчилан ашиглах зохицуулалтыг Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нарийвчлан тусгах хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;	100
2.1.3.5.Хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоог бий болгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, ирээдүйд ахмад настнууд олон эх үүсвэрээс тэтгэврээ авах боломжийг бүрдүүлнэ		
2.1.3.5	Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалыг нэвтрүүлэх хуулийн төслийг боловсруулж, Улсын Их хуралд өргөн мэдүүлэх;	90
2.1.3.6.Гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэний нийгмийн баталгааг хангах үүднээс нийгмийн хамгааллын хэлэлцээрийг үргэлжлүүлэн байгуулна.		
2.1.3.6.	Засгийн газар хоорондын нийгмийн хамгааллын хэлэлцээрийг шинээр байгуулах;	100
2.1.3.7.Нийгмийн даатгалын сангуудын засаглалыг сайжруулж, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлж, хөрөнгийн менежментийг ил тод, шилэн болгоно.		
2.1.3.7	Нийгмийн даатгалын сангийн мэдээллийг нээлттэй байршуулах замаар санхүүгийн тогтвортой байдлыг хангах;	100
3.1.3.6.Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл, тэтгэврийн нөөц сан, хувийн нэмэлт тэтгэврийн сангийн хөрөнгийн тодорхой хэсгийг эрх бүхий мэргэжлийн байгууллагын менежментээр хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.		
3.1.3.6	Тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг өсгөх, санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах санхүүгийн хэрэгслийг нэмэгдүүлж холбогдох хуульд нэмэлт оруулах;	90
3.2.1.5.Нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийг үргэлжлүүлэн ажил олгогч, даатгуулагчид харилцан өгөөжтэй байх эрх зүйн зохицуулалтыг нэвтрүүлнэ.		
3.2.1.5	Нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийг үргэлжлүүлэн иргэн, аж ахуйн нэгжид санхүүгийн дарамт нэмэхгүйгээр ажил олгогч, даатгуулагчид харилцан өгөөжтэй байх эрх зүйн зохицуулалтыг холбогдох хуульд нэмэлтээр оруулах хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;	90
3.2.1.6.Ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээгээр тохирсон хөдөлмөрийн хөлсөнд нийгмийн даатгалын шимтгэл ногдуулахдаа уян хатан, хөнгөлөлттэй байх нөхцөлийг бүрдүүлнэ.		
3.2.1.6	Ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээгээр тохирсон хөдөлмөрийн хөлсөнд нийгмийн даатгалын шимтгэл ногдуулахдаа уян хатан, хөнгөлөлттэй байх нөхцөлийг бүрдүүлэх;	90
Нийт дундаж үнэлгээ		91.7

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2025 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээний дүнгээр:

- Хэрэгжиж дууссан 100 хувийн хэрэгжилттэй “**Үр дүн гарсан**” 1 арга хэмжээ;
- Хугацаа дуусаагүй буюу хэрэгжиж байгаа 12 арга хэмжээ;

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2025 онд нийгмийн даатгалын чиглэлээр хэрэгжүүлэхээр тусгагдсан Нийгмийн даатгалын байгууллагын чиг үүрэгт хамаарах хугацаа дуусаагүй буюу хэрэгжиж байгаа цаашид үргэлжлүүлэн хэрэгжих 12 арга хэмжээний хэрэгжилтийг авч үзвэл:

“**Үр дүнтэй**” буюу 90-100 хувийн хэрэгжилттэй 11 арга хэмжээ байна. Үүнд:

- 100 хувийн хэрэгжилттэй 2 арга хэмжээ;
- 90-93.9 хувийн хэрэгжилттэй 9 арга хэмжээ

“**Үр дүн хүлээгдэж байгаа**” буюу 78.5 хувийн хэрэгжилттэй 1 арга хэмжээ байна.

Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг харуулбал:

Зорилт, арга хэмжээний дугаар	Зорилт, арга хэмжээ	Тайлбар
НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО		
Зорилго 3.12.1. Нийгмийн даатгалын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулсан байна.		
2.12.1.1	Үндэсний баялгийн сангаар дамжуулж хуримтлалын хөтөлбөрийг хэрэгжүүлж, иргэн бүрд хуримтлалын нэрийн дансанд хөрөнгө хуримтлуулах;	Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сангийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 8.2.1 дэх заалтад “Хуримтлалын сангийн тухайн жилийн төсвийн төслийг боловсруулж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх, батлагдсан төсвийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах, сангийн үйл ажиллагааны удирдлагыг хэрэгжүүлэх”, 8.2.2 дахь заалтад “Монгол Улсын иргэн бүрд хуримтлалын нэрийн данс үүсгэж, хөтлөх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах”, энэ хуулийн Монгол Улсын иргэн бүрд хуримтлалын данс үүсгэх, хөтлөх, сангаас зарцуулалт хийх журмыг боловсруулж Засгийн газарт хүргүүлэхээр тус тус заасан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийгмийн даатгалын салбарт хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 2026 оны эхний хагас жилийн байдлаар дунджаар 91.7 хувь буюу “**Үр дүнтэй**” гэж дүгнэж, тайланг Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2026 оны 02/1895 дугаар албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв.

2.4. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;

2.4.1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ:

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд 2025 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын хяналтад авсан Монгол Улсын хууль, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын албан даалгавар, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын нийт 37 шийдвэрийн 68 заалт байна.

Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд хяналтад авсан Монгол Улсын хууль, УИХ-ын байнгын хорооны тогтоол, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын албан даалгавар, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол зэрэг нийт 37 хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн 68 заалтын биелэлтийг 2025 оны жилийн эцсийн байдлаар 53 (88.3 хувь) нь “Хэрэгжсэн”, 7(5.83 хувь) нь “Хэрэгжих шатанд”, 8(11.8 хувь) нь “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй”-гээр тус тус дүгнэж, биелэлт (дунджаар)-ийг 94.2 хувиар үнэлж Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2026 оны 02/122 дугаар албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв

2.4.2.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх;

Нийгмийн даатгалын ерөнхий газар, Мэдээллийн технологийн төв, БНСУ дахь ХНХУ-ний төвийн Нийгмийн даатгалын тасаг, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын байгууллагын үйл ажиллагааны болон нийгмийн даатгалын сангийн мэдээллийг шилэн дансны цахим хуудас (shilendans.gov.mn)-т хуулийн хугацаанд үнэн зөв, бодитой мэдээлсэн эсэхэд 2026 оны 1 дүгээр улирлын байдлаар хяналт-шинжилгээ хийж холбогдох баримт бичигтэй тулган шалгав.

Хяналт шинжилгээгээр байгууллагын үйл ажиллагаа болон нийгмийн даатгалын сангийн нийт 2 119.1 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс:

- 8 617.0 тэрбум төгрөгийн 164 шийдвэр гүйлгээг мэдээлээгүй;
- 8 073.0 тэрбум төгрөгийн 130 шийдвэр гүйлгээг илүү мэдээлсэн;
- 2 103.7 тэрбум төгрөгийн 4 208 шийдвэр гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн ба хяналт шинжилгээний явцад зөрчлийг залруулж нөхөн мэдээлсэн 198.5 тэрбум төгрөгийн 95 шийдвэр гүйлгээ мэдээлэл байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээний дүн, танилцуулга, дүгнэлт, цаашид авах арга хэмжээний саналыг удирдлагад танилцуулахаар бэлтгэж байна.

2.4.2.2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, хугацаатай мэдээ тайланг гаргаж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэх;

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын 8.1-т зааснаар Нийгмийн даатгалын харьяа байгууллагуудын 2025 оны жилийн

эцэс, 2026 оны 1 дүгээр улирлын байдлаарх шилэн дансны хөтлөлтийн тайланг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэлд үндэслэн хяналт тавьж нэгтгэлийг 2025 оны жилийн эцэс, 2026 оны 01 дүгээр улирлын байдлаар гаргаж Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны “Шилэн дансны тухай хууль болон холбогдох журмыг хэрэгжүүлж ажиллах тухай” 03 дугаар албан даалгаврын биелэлт, шилэн дансны хөтлөлтийн 2025 оны 04 дүгээр улирлын тайланг Дотоод аудит, мониторингийн газрын даргын 02/95 дугаар албан бичгээр, 2026 оны 1 дүгээр улирлын тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны 01/432 дугаар албан бичгээр тус тус Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн

Нийгмийн даатгалын харьяа байгууллагуудын 2025 оны жилийн эцсийн шилэн дансны хөтлөлтийн тайлангаар шилэн дансны цахим хуудаст мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан Дундговь, Өмнөговь, Хөвсгөл аймаг, Сүхбаатар, Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын газраас бусад газруудад Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2026 оны “Мэдээлэл байршуулах тухай” ... дугаар албан бичгүүдийг тус тус хүргүүлсэн.

Шилэн дансны тухай хууль холбогдох журмын хэрэгжилтэд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй байх, дотоод хяналтыг сайжруулж үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах талаарх зөвлөмжийг Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2026 оны “Шилэн дансны цахим хуудаст мэдээлэл байршуулахтай холбоотой зөвлөмж хүргүүлэх тухай” 01/432 дугаар албан бичгээр Мэдээллийн технологийн төв, БНСУ дахь Нийгмийн даатгалын тасгийн дарга, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт хүргүүлэв

2.5.Байгууллагын мэдээллийн ил тод, нээлттэй байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;

1. Нийгмийн даатгалын ерөнхий газар, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын цахим хуудас (ndaatgal.mn)-т нээлттэй мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, хуулийн хугацаанд бодитой байршуулж байгаа эсэх (нээлттэй мэдээллийн ил тод байдал)-д хяналт тавьж ажиллав.

Нийгмийн даатгалын байгууллагын мэдээллийн ил тод нээлттэй байдалд 2026 оны 1 дүгээр улирлын байдлаар хийсэн хяналт-шинжилгээгээр салбарын хэмжээнд байгууллагын цахим хуудасны мэдээлэл нийтэлж байршуулсан байдал Нийгмийн даатгалын ерөнхий газар 77.8 хувь, салбарын хэмжээнд 87.6 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд:

- Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын мэдээллийн ил, тод нээлттэй байдал 88.9 хувь;
- Хүний нөөц талаар мэдээллийн ил, тод нээлттэй байдал 89.9 хувь;
- Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны мэдээллийн ил, тод нээлттэй байдал 87.6 хувь;
- Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил, тод нээлттэй байдал 88.0 хувь;
- Бусад мэдээллийн ил, тод нээлттэй байдал 80.0 хувьтай байна.

Мэдээлэл байршуулах үйл ажиллагааг сайжруулж, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах талаарх зөвлөмжийг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт хүргүүлэхээр бэлтгэж байна.

2.Нийгмийн даатгалын байгууллагын чиг үүрэгт хамаарах нээлттэй мэдээллийг олон нийтэд хүргэх, тэдний мэдээлэл авах эрхийг хангах зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны “Нээлттэй өгөгдөл байршуулах төлөвлөгөө, хуваарь батлах тухай” А/20 дугаар тушаалыг баталсан бөгөөд тушаалаар байршуулах мэдээллийн жагсаалт, мэдээлэл байршуулах нэгж, хугацаа, хуваарь зэргийг баталсан.

Тушаалын дагуу тус газраас байгууллагын цахим хуудаст бодлогын баримт бичигт болон тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээний тайлан, Шилэн дансны хөтлөлтийн тайлан, Дотоод аудит, мониторингийн газраас хийж хэрэгжүүлсэн аудит, хяналт шинжилгээний тайлан зэрэг нийт 22,678 kb хэмжээтэй 9 мэдээллийг гаргаж байгууллагын цахим хуудсанд байршуулж мэдээлэхээр Үйлчилгээ хөгжүүлэлт, олон нийттэй харилцах газарт хүргүүлсэн.

2.6. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх зорилтын хүрээнд:

2.6.1.Төсвийн ерөнхийлөн захирагч /Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд/-аас төсвийн шууд захирагч /Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга/-тай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;

Төсвийн ерөнхийлөн захирагч /Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд/-аас Төсвийн төвлөрүүлэн захирагч /Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга/-тай 2026 онд байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 11 зорилтын 60 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

- “Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, гадаад, дотоод харилцааг өргөжүүлж, ажил олгогч, даатгуулагчтай хамтран ажиллах” зорилгын хүрээнд 2 зорилт, 9 арга хэмжээ;
- “Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэн сангийн орлогыг бүрдүүлэн нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тогтвортой, бие даасан найдвартай байдлыг хангах замаар сангийн зарлагын гүйцэтгэлийг хангах, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардал, хөнгөлөлт, чөлөөлөлтийг хуулиар тогтоосон хугацаанд олгох, хяналт шалгалт, шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах” зорилгын хүрээнд 4 зорилт, 17 арга хэмжээ;
- “Нийгмийн даатгалын үйлчилгээ, мэдээллийн нэгдсэн санг боловсронгуй болгож, дэвшилтэт шинэ технологи нэвтрүүлэх, олон нийтэд мэдээлэх, сурталчлах” зорилгын хүрээнд 3 зорилт, 22 арга хэмжээ;
- “Даатгуулагчид, үйлчлүүлэгчдийн хэрэгцээнд нийцсэн, нийгмийн хариуцлага бүхий тогтолцоог бүрдүүлж хэрэгжүүлэх” зорилгын хүрээнд 2 зорилт 12 арга хэмжээ;

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтийг 92.8 хувиар үнэлж, үнэлгээний тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны 01/1685 дугаар албан бичгээр болон цахимаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн.

2.6.2.Төсвийн шууд захирагч /Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга/-аас зохион байгуулалтын нэгжийн даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;

Төсвийн шууд захирагч /Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга/-аас зохион байгуулалтын нэгжийн дарга нартай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2026 оны эхний хагас жилийн хэрэгжилт, биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Зохион байгуулалтын нэгжийн дарга нарын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 218 арга хэмжээг тусгаж, нэмэлт 26 ажил үйлчилгээг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- *Дотоод аудит, мониторингийн газар*: 33 арга хэмжээ, нэмэлт 9 арга хэмжээ;
- *Захиргаа удирдлагын газар*: 38 арга хэмжээ;
- *Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газар*: 26 арга хэмжээ, нэмэлт 16 арга хэмжээ;
- *Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газар*: 18 арга хэмжээ;
- *Үйлчилгээ хөгжүүлэлт, олон нийттэй харилцах газар*: 34 арга хэмжээ, нэмэлт 1 арга хэмжээ;
- *Хяналт шалгалтын газар*: 22 арга хэмжээ;
- *Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөл*: 25 арга хэмжээ;
- *Мэдээллийн технологийн төв*: 22 арга хэмжээ;

Зохион байгуулалтын нэгжийн 2026 оны гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний эхний хагас жилийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний дүнг харуулбал:

Зохион байгуулалтын нэгжийн үнэлгээний дүн

№	Газрын нэр	Гүйцэтгэлийн хувь
1	Дотоод аудит, мониторингийн газар	94.2
2	Захиргаа, удирдлагын газар	95.4
3	Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газар	95.3
4	Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газар	90.1
5	Үйлчилгээ хөгжүүлэлт, олон нийттэй харилцах газар	84.4
6	Хяналт шалгалтын газар	90.7
7	Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөл	91.0
8	Мэдээллийн технологийн төв	90.2
Нийт дундаж үнэлгээ		91.4

Нийгмийн даатгалын ерөнхий газрын Зохион байгуулалтын нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээгээр 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн явцын дунджийг 91.4 хувиар буюу “Бүрэн хангалттай” гэж дүгнэж удирдлагад танилцуулан дүнг, үнэлгээний тайлан, зөвлөмжийн хамт Захиргаа, удирдлагын газарт хүргүүлэв.

2.6.3.Төсвийн шууд захирагч /Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга/-аас зохион байгуулалтын нэгжийн даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;

Төсвийн төвлөрүүлэн захирагч /Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга/-аас Төсвийн шууд захирагч /Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга/-тай 2026 онд байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд 2026 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээг хийв.

Байгууллагын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 8 зорилт 62 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан.

Тус гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний 2026 оны эхний хагас жилийн биелэлтэд зохион байгуулалтын нэгжүүдээс өгсөн үнэлгээний дунджийг тус бүрээр нь харуулбал:

№	Нэгжийн нэр	Арга хэмжээний тоо	Үнэлгээ /дундаж оноо/
1	Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газар	4	90.4
2	Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газар	18	93.9
3	Дотоод аудит, мониторингийн газар	3	83.7
4	Хяналт шалгалтын газар	8	84.3
5	Захиргаа, удирдлагын газар	14	89.0
6	Үйлчилгээ хөгжүүлэлт, олон нийттэй харилцах газар	8	94.9
7	Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөл	5	84.4
8	Мэдээллийн технологийн төв	2	91.5
Нийт дундаж үнэлгээ		62	89.0

Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын 2026 оны гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний эхний хагас жилийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний дүнг аймаг, дүүргээр нь харуулбал:

№	Газрын нэр	БХТГ	СБХОГ	ДАМГ	ХШГ	ҮХОНХГ	МТТ	ЭММТЗ	ЗУГ	Нийт дундаж
1	Архангай	91.3	91.8	80.9	81.2	94.4	92.9	80.0	90.2	87.8
2	Баян-Өлгий	90.3	95.3	89.5	81.0	95.1	95.6	93.0	87.2	90.9
3	Баянхонгор	94.3	94.1	89.0	90.9	98.3	94.5	80.0	84.2	90.6
4	Булган	89.3	90.8	91.4	82.1	95.4	89.1	88.0	90.8	89.6
5	Говь-Алтай	91.0	96.6	86.5	89.2	98.7	93.0	82.0	90.8	91.0
6	Говьсүмбэр	87.3	91.4	85.5	90.0	98.8	89.1	80.0	86.2	88.5
7	Дархан-Уул	92.3	95.2	87.0	86.2	97.9	94.7	90.0	92.5	92.0
8	Дорнод	94.0	95.4	88.3	85.3	98.4	93.4	87.0	91.2	91.6
9	Дорноговь	92.8	96.4	81.7	82.3	99.0	94.2	81.0	86.5	89.2
10	Дундговь	92.0	98.3	91.0	76.8	98.1	96.3	89.0	89.7	91.4
11	Завхан	91.0	95.8	81.6	80.7	86.8	90.3	84.0	82.4	86.6
12	Орхон	90.0	92.3	90.1	90.3	92.7	94.5	96.0	91.9	92.2
13	Өвөрхангай	90.8	98.1	89.3	78.8	99.0	91.7	92.0	92.3	91.5
14	Өмнөговь	94.0	94.4	82.2	84.9	81.9	92.3	80.0	89.8	87.4
15	Сүхбаатар	91.3	90.3	88.0	74.5	94.4	91.9	80.0	89.8	87.5
16	Сэлэнгэ	86.8	89.2	83.0	88.9	96.5	85.5	80.0	90.2	87.5
17	Төв	89.8	94.4	83.6	83.4	98.8	91.7	88.0	91.0	90.1
18	Увс	91.5	90.8	85.8	83.7	95.6	96.0	80.0	88.2	89.0
19	Ховд	90.8	98.0	88.5	94.5	96.9	86.9	82.0	88.8	90.8
20	Хэнтий	90.5	96.9	44.8	88.7	90.4	95.2	80.0	88.1	84.3
21	Хөвсгөл	89.3	95.3	89.8	84.8	100	87.1	93.0	86.8	90.8
22	Баянгол	89.5	95.0	85.3	83.9	99.3	90.2	81.0	88.8	89.1
23	Баянзүрх	88.8	93.8	89.3	83.5	99.6	90	84.0	92.2	90.1
24	Багахангай	85.8	94.5	90.5	77.4	77.8	90.4		90.8	86.7

25	Багануур	92.0	92.9	86.8	80.2	95.0	90.6	93.0	93.1	90.4
26	Сүхбаатар	89.8	89.9	82.5	82.8	97.8	92.5	90.0	90.2	89.4
27	Сонгинохайрхан	89.0	92.7	86.8	86.3	94.5	92.2	80.0	91.0	89.1
28	Хан-Уул	88.5	96.6	89.5	87.4	93.4	89.6	80.0	88.1	89.1
29	Чингэлтэй	88.5	89.2	38.5	83.0	84.8	84.4	74.0	79.5	77.7
30	Налайх	89.0	91.4	85.0	85.9	96.3	90.9	80.0	88.1	88.3
Нийт дүн		90.4	93.9	83.7	84.3	94.9	91.5	84.4	89.0	89.0

Хяналт-шинжилгээ үнэлгээний дүнг нэгтгэлээр харуулбал:

- 90.1-92.2 оноогоор үнэлэгдсэн 2 дүүрэг, 11 аймгийн Нийгмийн даатгалын газар;
- 86.6-89.6 оноогоор үнэлэгдсэн 9 аймаг, 6 дүүргийн Нийгмийн даатгалын газар;
- 77.7 оноогоор үнэлэгдсэн 1 аймаг, 1 дүүргийн Нийгмийн даатгалын газар байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргаас аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нартай байгуулсан 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн дунджийг эхний хагас жилийн байдлаар 89.0 хувь буюу **“Бүрэн хангалттай”** гэж үнэлж, хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн тайлан, 21 аймаг, 9 дүүргийн үнэлгээний тайлан, үнэлгээний хуудсыг Захиргаа удирдлагын газарт тус тус хүргүүлсэн.

3.Удирдлага зохион байгуулалт

3.1.Салбарын үйл ажиллагааг үр дүнтэй байлгах чиглэлээр бусад байгууллагуудтай хамтран ажиллах:

3.1.Үйл ажиллагаанд RPA технологи буюу робот автоматжуулалтыг үргэлжлүүлэх, сайжруулах, нэвтрүүлэх

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газар, “Би Пи Солюшн” ХХК-тай 2025 оны 07 дугаар сарын 22-ны өдөр 2025/0701 дугаар Ажил гүйцэтгэх гэрээг байгуулж Шилэн дансны цахим хуудас (Shilen.dans.gov.mn)-т Нийгмийн даатгалын сангийн “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ”, “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ” төрөлд байршуулах 2 мэдээллийг автоматаар оруулах үйл ажиллагаа 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэн.

Уг робот автоматжуулалтыг сайжруулж мэдээллийн гүйлгээний огноогоор давхардал шалгаж, гүйлгээ нөхөж оруулах үйл ажиллагаанд гүйлгээг он, сар, өдрөөр бус, ID дугаараар таньдаг болж, оруулсан мэдээлэл, давхардах, дутуу бүртгэх эрсдэл гарахгүй байхаар нэмэлт хөгжүүлэлтийг хийв.

3.2. Ажил олгогч, даатгуулагч, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлт болон бусад байгууллагаас ирүүлсэн хугацаатай албан бичгийг хуульд заасан хугацаанд хариуг хүргүүлэх, зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах;

Тайлант хугацаанд Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллага болон ажил олгогч, харилцагч бусад байгууллагаас тус газарт хандаж 201 албан бичиг ирснээс 41 албан бичиг нь хариутай, иргэд, даатгуулагчаас 9 өргөдөл, гомдол ирүүлсэн ба 717 албан бичгийг бусад газруудад хүргүүлсэн байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хоног 12.3 байна.

4.Төсөв санхүүгийн үйл ажиллагаа

Тус газар нь эрхэлсэн ажлын хүрээнд 21 аймаг, 9 дүүргийн хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ болон аудитыг хийж гүйцэтгэдэг ба холбогдох тайлан мэдээ, санхүүгийн баримтыг цахимаар авч ажилласан.

Мөн Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын газрын санхүү, үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийсэн бөгөөд томилолтын зардалд 1.4 сая төгрөгийг зарцуулсан.

Нэгжийн албан хаагчийн ажлын ачаалал их орон тоог нэмэгдүүлэх шаардлагатай.

5.Бусад мэдээлэл

5.1. Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан биелээгүй ажил үйлчилгээ:

Нийгмийн даатгалын мэргэшлийн зэргийн нэмэгдэл авч байгаа байцаагчдын нэрсийн жагсаалтад хяналт-шинжилгээ хийх; (Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 5.2.5 дахь арга хэмжээ)

5.2. Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан үндсэн үүрэг, нэгжийн дотоод ажил үүрэг

5.2.1. Иргэдээс Нийгмийн даатгалын байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын агуулга, шийдвэрлэлтийн чанар байдал, өргөдөл гомдолд тусгагдсан асуудлуудад хяналт- шинжилгээ хийх;

Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, албан тушаалтанд 2026 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын бүртгэл, түүнд ашиглаж байгаа программ, өргөдөл, гомдлын агуулга, шийдвэрлэлтийн байдал, өргөдөл гомдолд тусгагдсан асуудлууд, шийдвэрлэлтийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийв.

Шинжилгээг дараах чиглэлийн дагуу гүйцэтгэсэн болно. Үүнд:

- Өргөдөл гомдлын бүртгэл, түүнд ашиглаж байгаа программын ашиглалт;
- Өргөдөл, гомдлын жил, улирлын мэдээний чанар;
- Бүртгэлд өргөдөл гомдлын утга, агуулгыг бүртгэсэн байдал, чиг хандлага;
- Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн үйл ажиллагаа, бүртгэлд өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг бүртгэсэн байдал, шийдвэрлэлт хуулийн хүрээнд явагдаж байгаа эсэх;
- Нийгмийн даатгалын байгууллагаас өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар хийж хэрэгжүүлсэн ажил;

Хяналт-шинжилгээгээр илэрсэн алдаа дутагдал, зөрчил, дүгнэлтийг гаргаж, цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулж хяналт-шинжилгээний дүн мэдээ, тайланг цахимаар 2026 оны 05 дугаар сарын 24—ний өдөр хүргүүлсэн.

5.2.2. Нийгмийн даатгалын мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох байцаагч, албан хаагчдын нэрсийн жагсаалтад хяналт тавьж, нэрсийн жагсаалтыг холбогдох газарт хүргүүлэх;

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны “Журам батлах тухай” А/137 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын улсын байцаагчид мэргэшлийн зэргийг тогтоох, зэргийн нэмэгдэл олгох журам”-д заасны дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газар, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газарт ажиллаж байгаа нийгмийн даатгалын улсын байцаагчдын нэрсийн жагсаалтад 2026 оны 4 дүгээр сарын 06-ны өдрөөс 09-ний өдрүүдэд хяналт-шинжилгээ хийв.

Захиргаа удирдлагын газраас тэргүүлэх мэргэшлийн зэрэг олгох байцаагчийн нэрсийн жагсаалтад мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох шалгуур хангасан эсэхийг нийгмийн даатгалын байцаагчаар ажилласан хугацааны нотлох баримт, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээ, ёс зүйн зөрчил, сахилгын шийтгэлтэй эсэх зэрэг холбогдох баримт бичигтэй тулган нягтлав.

Мэргэшлийн зэрэг олгох байцаагчийн тоог харуулбал:

Мэргэшлийн зэргийн ангилал	ЗУГ- ас ирүүлсэн	Нэмэгдсэн	Хасагдсан	МШЗ олгох албан хаагчийн тоо
Тэргүүлэх	39		3	36
Зөвлөх	37	3	3	37
Итгэмжит	44	3	3	44
Нийт	120	6	9	117

Мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох албан хаагчийн болон хасагдах албан хаагчийн нэрс, тайлбарын хамт жагсаалтын хамт гаргаж Захиргаа удирдлагын газарт хүргүүлсэн.

5.2.3. Нийгмийн даатгалын байгууллагаас 2027 онд өндөр насны тэтгэвэрт гарах албан хаагчдад олгох нэг удаагийн тэтгэмжийн тооцоололд хяналт хийх (Төсвийн төсөл);

Нийгмийн даатгалын ерөнхий газар, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудаас байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын 2026 оны төсвийн төслийн саналд тусгах төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламжийн тооцооллыг холбогдох баримт бичгийг үндэслэн тулган шалгав.

Хяналт-шинжилгээг дараах чиглэлийн дагуу гүйцэтгэсэн болно. Үүнд:

- Төрийн албан хаагчийн төрийн албанд ажилласан хугацаа, нэг удаагийн буцалтгүй тусламж олгох дундаж цалин хөлсийг зөв тооцсон эсэх;
- Нийт олгох тусламжийн хэмжээг зөв тодорхойлсон эсэх;

Хяналт-шинжилгээгээр 34 албан хаагчид 1 187.8 сая сая төгрөгийн өндөр насны тэтгэвэр гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламж олгох тооцооллыг хийж Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газарт 2026 оны 06 дугаар сарын 22-ны өдөр хүргүүлсэн.

5.2.4. “Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын хэрэгжилт, 2026 онд олгох мөнгөн урамшууллын тооцооллыг хянах (Төсвийн төсөл);

Аймаг, сум болон нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүргийн Нийгмийн даатгалын газруудаас байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын 2027 оны төсвийн төслийн саналд тусгах төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшууллын тооцооллыг холбогдох баримт бичгийг үндэслэн тулган шалгав.

Хяналт-шинжилгээг дараах чиглэлийн дагуу гүйцэтгэсэн болно. Үүнд:

- Төрийн захиргааны албан тушаалд ажилласан хугацаа, мөнгөн урамшуулал олгох дундаж цалин хөлсийг зөв тооцсон эсэх;
- Нийт олгох тусламжийн хэмжээг зөв тодорхойлсон эсэх;

Хяналт-шинжилгээгээр 30 албан хаагчид олгох 269.6 сая төгрөгийн мөнгөн олгох тооцооллыг хийж Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газарт 2026 оны 06 дугаар сарын 18-ны өдөр хүргүүлсэн.

Мөн 31 албан хаагчид олгох 271.8 сая төгрөгийн тооцоолол хийгдсэн 5 жил тутамд олгох 1 удаагийн мөнгөн урамшуулал авах эрх үүсэхгүй талаарх мэдээллийг холбогдох газруудад мэдэгдэж албан хаагчийн нэрсийн жагсаалтыг Захиргаа удирдлагын газрын хүний нөөцийн мэргэжилтэн Б.Эрдэнэчимэгт 2026 оны 06 дугаар сарын 18-ны өдөр хүргүүлсэн.

5.2.5. Эрсдэлийн үнэлгээ хийх журам боловсруулж батлуулах;

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас ирүүлсэн 2026 оны 01/65 дугаар албан бичгийн дагуу байгууллагын эрсдэлийн удирдлагын төлөвлөлийн үнэлгээг хийж 2026 оны төлөвлөгөөний саналыг боловсруулж Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны 01/382 дугаар албан бичгээр тус газарт хүргүүлсэн.

Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны 2025 оны 03 дугаар тогтоолоор баталсан “Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын удирдлагын бодлого”, “Төрийн байгууллагад эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх заавар”, “Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг үнэлэх аргачлал”-д нийцүүлэн нийгмийн даатгалын байгууллагын зорилго, үндсэн чиглэл, үйл ажиллагаа, эрсдэл, стратеги зорилттой уялдуулан “Нийгмийн даатгалын байгууллагын эрсдэлийн удирдлагын бодлого”-ын төслийг боловсруулж, дотоод зохион байгуулалтын нэгжүүдээс санал авч байна.

Тус зааварт ирүүлсэн саналыг нэгтгэн холбогдох заалтыг тусган батлуулахаар ажиллаж байна.

5.2.6. Цахим үйлчилгээний заавар боловсруулж батлуулах;

Нийгмийн даатгалын байгууллагын үзүүлж байгаа цахим үйлчилгээний программ хангамжийн нэвтрэх эрх, нууцлал, аюулгүй байдлыг хангах, баримт бичгийг баталгаажуулах, анхан шатны баримт бүрдүүлэх, цахимаар хадгалах үйл ажиллагааг зохицуулсан “Нийгмийн даатгалын байгууллагын цахим үйлчилгээний заавар”-ыг боловсруулж, холбогдох газар, нэгжүүдээс саналыг авч тусган Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны А/175 дугаар тушаалаар баталсан

Батлагдсан зааврыг хэрэгжүүлж үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг 2026 оны “Заавар хүргүүлэх тухай” 02/1798 дугаар албан бичгээр аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт хүргүүлсэн.

5.2.7. УИХ-ын Тамгын газрын дэргэдэх парламентын судалгааны хүрээлэнтэй хамтран судалгаа хийх;

МУИХ-ын Тамгын газар, Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн захирлын 2026 оны “Мэдээлэл хүсэх тухай” ПС-01/0019 дүгээр албан бичгээр Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн зарим зүйл, заалтын нийгэм, эдийн засагт үзүүлж буй нөлөөллийг судлах судалгааны удирдамжид тусгагдсан Нийгмийн даатгалын ерөнхий хуулийг зөрчигчид хүлээлгэсэн хариуцлагын тоон мэдээ шаардлагатай талаар хүсэлт ирүүлсэн.

Уг албан бичгийн дагуу Нийгмийн даатгалын ерөнхий хууль болон Зөрчлийн тухай хууль зөрчсөн үйлдэлд хүлээлгэсэн хариуцлагын талаарх судалгаа, мэдээллийг салбарын хэмжээнд нэгтгэн, мэдээллийг Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2026 оны 02/582 дугаар албан бичгээр хүргүүлсэн. (Цахим файл 0.9 GB)

5.2.8. Үндэсний аудитын газраас хийсэн нийгмийн даатгалын байгууллагын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил, өгөгдсөн акт, албан шаардлага зөвлөмжийн биелэлтийг нэгтгэн холбогдох газруудад хүргүүлэх;

Үндэсний аудитын газраас нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллага, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нэгтгэв.

Алдаа, зөрчлийн дүнг дараах байдлаар харуулав.

/Сая.төг/

		Үйл ажиллагаа	Сан	Нийт дүн	
Алдаа /залруулга/	Тоо	28	-	28	
	Дүн	493,156.7	-	493,157	
Төлбөрийн акт	Тоо	13	1	14	
	Дүн	16,670.7	733.7	17,404	
Албан шаардлага	Тоо	17	15	32	
	Дүн	155,176.4	158,688,705.1	158,843,882	
Зөвлөмж	Тоо	37	35	72	
	Дүн	497,748.1	10,431,937.0	10,929,685	
Нийцлийн аудит	Шилэн данс	Тоо	6	2	8
		Дүн	207,805.1	-	207,805
	Хуулийн хэрэгжилт	Тоо	7	4	11
		Дүн	2,911,195.7	65,200.6	2,976,396
Нийт дүн		Тоо	108	57	165
		Дүн	4,281,752.7	169,186,576.4	173,468,329

Санхүүгийн тайлангийн аудитаар салбарын хэмжээнд нийт 173 468 329 сая төгрөгийн төлбөр, зөрчил илэрснээс:

- Санхүүгийн тайланд 493 157 сая төгрөгийн залруулга;
- 17 404 сая төгрөгийн 14 акт;
- 158 843 882 сая төгрөгийн 32 албан шаардлага;
- 10 929 685 сая төгрөгийн 72 зөвлөмж;

Байгууллагын болон нийгмийн даатгалын сангийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүнгийн нэгтгэлээр 22 тайланг түүврээр шалгасан бөгөөд бусад тайланд дараах дүгнэлт өгөгдсөн байна. Үүнд:

- Өөрчлөлтгүй 42;
- Хязгаарлалттай 2;

Санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор нэгтгэнэ.

5.2.9.Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, эрх сэргээх, эрх баталгаажуулах шалгалтад орох байцаагч, ажилтнуудын нэрсийн жагсаалтад мониторинг хийж, ажлын хэсэгт хүргүүлэх;

Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, баталгаажуулах, сэргээх шалгалтыг 2026 оны 04 дүгэр сарын 25-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулсан.

Энэхүү ажлын хүрээнд Захиргаа удирдлагын газраас ирүүлсэн нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, баталгаажуулах, сэргээх шалгалтад орох нийт 275 албан хаагчдын нэрсийн жагсаалтад Гэр бүл, хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын 2026 оны А05 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын улсын байцаагчийн шалгалтын журам”-д заасан нөхцөл, шалгуурыг хангасан эсэхийг холбогдох, баримт бичигтэй тулган нягталж, улсын байцаагчийн эрх шинээр олгох, баталгаажуулах, сэргээх болон журмын 2.2, 2.3, 2.6-д заасан нөхцөл шалгуурыг хангасан шалгалтад орох 270 албан хаагч, шалгуур хангаагүй 5 албан хаагчдын нэрсийн жагсаалтыг гаргаж Ажлын хэсэгт хүргүүлсэн.

5.3. ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС АЖЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

5.3.1.Албан тушаалын гэмт хэрэгтэй холбоотой судалгаа, мэдээллийг гаргаж нэгтгэж удирдлагад танилцуулах

Салбарын хэмжээнд гарч байгаа албан тушаалын гэмт хэрэгтэй холбоотой судалгааг гаргаж нэгтгэж удирдлагад танилцуулав.

Судалгааны дүнд үндэслэн байгууллагын үйл ажиллагаанд хууль ёс, шударга, ил тод, хариуцлагатай байдлыг бүх түвшинд хангах, авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын болон болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, нөлөөлж буй хүчин зүйлийн шалтгаан нөхцөлийг арилгах зорилгоор арга хэмжээг зохион байгуулж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх тухай чиглэлийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны “Чиглэл хүргүүлэх тухай” 01/438 дугаар албан бичгээр аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт хүргүүлэв.

5.3.2.Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны А/30 дугаар тушаалаар баталсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллах

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/30 дугаар тушаалаар баталсан Улсын Их Хурлаас Нийгмийн даатгалын сангийн асуудлаар нээлттэй сонсгол зохион байгуулахаар төлөвлөсөнтэй холбоотой бэлтгэл ажлыг хангах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллав.

Тус тушаалаар баталсан ажил, үүргийн хуваарийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, хяналт шалгалт, мэдээллийн ил тод, нээлттэй байдал, шилэн дансны хуулийн хэрэгжилт, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаарх танилцуулга, судалгаа, мэдээллийг 2018-2025 онуудыг хамруулан бэлтгэж ажлын хэсгийн нарийн бичгийн дарга А.Уртнасанд хүргүүлэв.

5.3.3.Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны А/47 дугаар тушаалаар баталсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллах

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны “Ажлын хэсэг байгуулах, ажил үүргийн хуваарь батлах тухай” А/47 дугаар тушаалаар баталсан Дэлхийн Банкны Монгол дахь суурин төлөөлөгчийн газарт хүсэлтийн дагуу “Нийгмийн даатгалын удирдлага, зохион байгуулалтын шинжилгээ хийлгэх” ажлын хүрээнд захиргааны 8 модуль асуумжид мэдээлэл бэлтгэх, цахим системд оруулах, шинжилгээ хийлгэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллав.

Тус тушаалаар баталсан ажил, үүргийн хуваарийн дагуу Дотоод засаглал модулийн 11 бүлэг 101 асуумж, мэдээллийг холбогдох газруудаас авч хянаж, дэлгэрүүлж бэлтгэн нотлох баримтыг хавсарган цахим системд оруулан 2026 оны 03 дугаар сарын 13-ны өдөр илгээв.

Мөн Дэлхийн банкнаас ирүүлсэн нэмэлт тодруулга, мэдээллийг бэлтгэн ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Б.Бямбадэлгэрт 2026 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр хавсралтын хамт хүргүүлэв.

5.3.4.Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны “Ажлын хэсэг байгуулах, удирдамж батлах тухай” А/76 дугаар тушаалаар Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын газарт, А/119 дүгээр тушаалаар Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газарт ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллах;

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны “Ажлын хэсэг байгуулах, удирдамж батлах тухай” А/76 дугаар тушаалаар Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын газарт 2026 оны 03 дугаар сарын 27-ны өдрөөс 04 дүгээр сарын 09-ний өдрийг дуусталх хугацаанд, А/119 дүгээр тушаалаар Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газарт ажлын хэсгийн бүрэлдэхүүнд 2026 оны 04 дүгээр сарын 2-ний өдрөөс 05 дугаар сарын 08-ны өдрийг дуусталх хугацаанд ажиллав.

Дээрх тушаалаар баталсан удирдамжийн дагуу тус газрын байгууллагын санхүү, үйл ажиллагаа, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт, биелэлтийг хянаж холбогдох албан хаагчдад зөвлөмж өгч мэргэшил арга зүйгээр хангаж ажиллав.

5.3.5. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан захиргааны хэм хэмжээний актад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэх;

Захиргааны ерөнхий хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2025 оны “Захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэх зарим арга хэмжээний тухай” 206 дугаар тогтоол, 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 33 дугаар хуралдааны тэмдэглэл, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2026 оны 1/1263 дугаар албан бичгийг үндэслэн захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан захиргааны хэм хэмжээний актад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Тус шинжилгээг дараах 2 чиглэлийн дагуу хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1.Дараах чиглэлийн дагуу судалгаа гаргах;

- Хуулиар тусгайлан эрх олгосны дагуу баталсан боловч бүртгүүлээгүй захиргааны хэм хэмжээний акт;
- Хуулиар эрх олгосон боловч батлаагүй захиргааны хэм хэмжээний акт;
- Хуулиар тусгайлан эрх олгогдоогүй боловч нийтээр дагаж мөрдүүлэхээр баталсан хэм хэмжээ тогтоосон шийдвэр;

2.Дээрх судалгаанд үндэслэн Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан захиргааны хэм хэмжээний актад хяналт-шинжилгээг дараах чиглэлийн дагуу хийв. Үүнд:

- Хуулиар тусгайлан эрх олгогдоогүй бөгөөд нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр баталсан дүрэм, журам, заавар, аргачлалыг хүчингүй болгох;
- Эрх зүйн зохицуулалтын ач холбогдлоо алдаж дагаж мөрдөхгүй болсон, хууль тогтоомжтой зөрчилдсөн, эрх олгосон хуулийн заалт нь хүчингүй болсон захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгох;
- Эрхлэх асуудлын хүрээнд хамаарах захиргааны хэм хэмжээний актын хууль зүйн үндэслэлийг нягтлан шалгаж, хуулиар тогтоосон хязгаарлалтаас гадуур хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, ашиг сонирхлын зөрчил, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн шинжтэй дүрэм, журам, тэдгээрийн холбогдох зохицуулалтыг хүчингүй болгох, өөрчлөх;
- Хуульд заасны дагуу баталсан боловч бүртгүүлээгүй захиргааны хэм хэмжээний актыг Захиргааны ерөнхий хуулийн 60, 61, 62 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасны үндсэн дээр захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх;
- Тэмдэглэх хэсэгт үндэслэл болгосон хуулиар тусгайлан эрх олгосон хуулийн заалтад өөрчлөлт орсон эсэх
- Хавсралтаар баталсан журмын доторх эшлэл хийсэн хуулийн заалтад өөрчлөлт орсон эсэхийг нягталж, өөрчлөлт орсон тохиолдолд захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд хөдөлгөөн хийлгэх.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан 7 захиргааны хэм хэмжээний актад хийсэн хяналт-шинжилгээний үр дүн, танилцуулга, дүгнэлт, цаашид авах арга хэмжээний саналыг удирдлагад танилцуулж Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны 01/1181 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

5.3.6. Нэр бүхий 49 холбогдогчтой Эрүүгийн 1813003640097 дугаартай хэрэгт хохирогчийн хууль ёсны төлөөлөгчөөр оролцох;

Нэр бүхий 49 холбогдогчтой Эрүүгийн 1813003640097 дугаартай хэрэгт хохирогчийн хууль ёсны төлөөлөгчөөр оролцож Ховд аймагт 2026 оны 05 сарын 19-ний өдрөөс 29-ний өдрүүдэд ажиллав.

Томилолтын хугацаанд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- Ховд аймгийн эрүүгийн анхан шатны шүүх хуралдаанд 2026 оны 05 дугаар сарын 26-ны өдөр оролцов.
- Уг хэрэгт холбоотой 278 хавтаст хэрэгтэй танилцав.
- Хэрэгт авагдаагүй үндэслэлгүйгээр, хөдөлмөрийн чадварын алдалтын хувь, хугацаа тогтоосон актад үндэслэн хийсэн тооцооллыг шүүхэд гаргаж өгөв.
- Мөн ЭМЯамны дэргэдэх мэргэжлийн салбар зөвлөл, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн хамтарсан шинжээчдийн дүгнэлтийг үндэслэн 4 хүний тооцооллыг нэмж хийв,

- Мөн өмнөх тооцооллуудыг шалган нийт 221 хүний 2 643.0 сая төгрөгийн хохирлын тооцоог гаргав.
- Мөн уг хэрэгт холбоотой 423 иргэдийн нэрсийг яллагдагч тус бүрээр жагсаалтыг гаргав.

5.3.7. Нийгмийн даатгалын улсын байцаагчийн шалгалт зохион байгуулах ажлын хэсэгт ажиллах;

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны “Ажлын хэсгийн бүрэлдэхүүн батлах тухай” А/41 дүгээр тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргатай нууц хадгалах гэрээг байгуулж Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, эрх сэргээх, эрх баталгаажуулах шалгалтын сорилын сан бүрдүүлэх, шинэчлэн боловсруулах, хянах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж ажлын хэсгээс ирүүлсэн 6 хуулийн хүрээнд ерөнхий мэдлэг шалгах 205 сорил, 80 онол арга зүйн бодлогыг шинээр болон шинэчлэн боловсруулан хянаж нягталж ажлын хэсэгт 2026 оны 03 дугаар сарын 13-ны өдөр хүргүүлсэн.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны “Улсын байцаагчийн шалгалт зохион байгуулах Дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүн, шалгалтын хуудасны загвар батлах тухай” А/65 дугаар тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулсан нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, баталгаажуулах, сэргээх шалгалтын бүрэлдэхүүнд ажиллав.

Уг ажлын хүрээнд 48 албан хаагчаас ерөнхий мэдлэгийн, онол, арга зүйн, албан хэрэг хөтлөлтийн шалгалтыг авч, шалгуулагчид шалгалтын дүнг танилцуулан гарын үсэг зуруулж, дүн мэдээг гаргаж холбогдох баримт бичгийг 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр ажлын хэсэгт хүргүүлсэн.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын Захиргаа удирдлагын газрын даргын баталсан “Нийгмийн даатгалын улсын байцаагчийн шалгалтад бэлтгэх сургалтын хөтөлбөр”-т заасан Монгол Улсын Үндсэн хууль Аудитын тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хууль зэрэг сэдвийн хүрээнд цахим хичээлийг 2026 оны 4 дүгээр сарын 15-ний өдөр зохион байгуулсан.

Уг сургалтад давхардсан тоогоор 413 албан хаагч цахимаар хамрагдав.

Мөн Захиргаа, удирдлагын газрын даргын баталсан “Нийгмийн даатгалын байгууллагаас 2026 оны эхний хагас жилд зохион байгуулах” мэдээллийн цагийн хуваарийн дагуу Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газартай хамтран “Нээлттэй мэдээллийн систем”, “Шилэн индекс”, “Мэдээлэл байршуулахад анхаарах асуудал” сэдвээр 2026 оны 03 дугаар сарын 06-ны өдөр, “Ажлын байрны стрессийг бууруулах нь” сэдвээр Мэргэжилтэн Ю.Түвшин-Ундрах 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр мэдээллийн цагийг зохион байгуулав.

Мэдээллийн цагт 58 албан хаагч танхимаар, 198 албан хаагч цахимаар нийт 256 оролцов.

5.3.8. Бусад ажлын талаар;

Мөн Өмч хамгаалах байнгын зөвлөлийн бүрэлдэхүүнд ажиллах, хэрэгт хохирогчийн хууль ёсны төлөөлөгчөөр оролцох, маргаан хянан шийдвэрлэх зөвлөл, улсын байцаагчийн тогтоосон акт, албан шаардлагыг өөрчлөх, хүчингүй болгох талаар санал боловсруулах, шалгах, дүгнэлт гаргах, үнэлгээний баг зэрэг ажлын хэсэгт орж ажилласан ба холбогдох тайлан, мэдээ, судалгаа, мэдээллийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, Үндэсний аудитын газар, Хяналт хэрэгжүүлэх газар

мөн Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газар, Захиргаа удирдлагын газарт хүргүүлж ажиллав.

6.Дүгнэлт

Тус газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 33 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж нэмэлтээр 9 арга хэмжээг хэрэгжүүлж төлөвлөгөөний биелэлт 2026 оны эхний хагас жилийн байдлаар 94.2 хувиар үнэлэгдсэн.

--oOo---